

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Данзангийн Очирхуяг	Дугаар	L050
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баян-Уул сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Баян-Уул сум	Төрсөн он	1950
Ажил мэргэжил	“Батсүмбэр” эзэмшлийн дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хэрийн дуган	Сүм хийдийн дугаар	ДОБУ 027
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд



Хэрийн дуганын тухай өөрийн мэдэх зүйлээ ярьж өгнө үү?

Хэрийн дуган анх 1920-иод оны үед бий болж байгуулагдсан. Анх Хэрийн зүүн биед байгуулагдсан. Одоо тэнд Хэнтийн 5-р застав байгаа. Дараа нь энд нүүж ирж нэлээд хэдэн жил болсон. Хийдийг энд байрлаж байхад Эрдэнэцагааны Егүзэр хутагт энд хоёр, гурван ч удаа ирж байсан гэдэг. Энд Хондон гэдэг уул байдаг юм. Тэндээс газар гүйж Лүйжин уншсан юм гэдэг. Настай улсуудаа тавьж байгаарай гэж манай аав хэлж захиж байсан. Энүүхэн хамрын цаана манай өвгөд дээдсийг нутаглуулдаг газар байдаг. Би аавыгаа Баян-Уул сумаас авчирч энд нутаглуулж байсан юм. Тэгээд эндээсээ энэ хийд маань Хужиртай руу нүүсэн.

-Хэрийн дуганд хэдэн лам байсан бол оо?

Нэлээн олон байсан гэсэн. Энд чинь хүний төөрөг энэ тэрийг үздэг. Тэгээд яг хэлснээр нь болдог. Манай хөгшин ээжийн төөрөг л яг таарч байсан. Нас барахдаа яг л хэлснээр нь болж байсан. Тийм айхтар л гаргаж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

өгдөг хийд байсан юм гэнэлээ. Манай аав хожим болтол байсан. Энэ хийдийн юм хумыг уншина. Цагаан сараар юм өргөнө.

-Энд яг хэдэн дуган байсан бэ?

Хоёр том дуган байсан.

-Хурал номын уншлагын хувьд ямархуу хийд байсан бэ?

Дөрвөн улиралд хурдаг тогтмол хуралтай газар байсан гэсэн. Ер нь энэ хийдийн гарал үүсэл Буриадын Цүүгэл дацангаас үүсэлтэй юм гэдэг. Тэгээд Сэрүүн дуган, Гилбэрийн дуган гээд газруудтай харилцаа холбоотой байсан гэдэг. Нэг буриад лам байсан. Их номтой.

-Энэ дуганын туурь маань одоо яг ямар нэртэй газар байна вэ?

Онон Балжийн ай савын Ар Өнөрч гэдэг газар байна. Газрын нэрээр Өнөрчийн дуган ч гэж нэрлэж болно.

-Хийд бурханы шашны аль урсгал нь бол? Улааны юмүү шарын?

Шарын тал байх аа. Их л бурхан тахидаг байсан. Энд шавилан сууж байсан лам нараас сүүлийн үе хүртэл л хэд хэдэн хүн байсан. Тэд нараас яг энэ тухай асууж лавлаж байсангүй.

-Морхоо, Дамбий гээд лам нар энд сууж байсан уу?

Дамбий гэж лам байсан.

-Лам нар бүгдээрээ баригдана. Морхоо ганцаараа үлдэж амьтны тусыг үйлдэнэ гэсэн гэж.

Өө тийм. Морхоо гэдэг нь бариа тавианд ороогүй үлдсэн хүн байсан. Ганцаараа бүр саяхан болтол байсан шүү. Банзрагчийн Дамдин гэж хүн бариа тавианд ороогүй. Бас энэ хийдийнх.

-Энэ хийд Хужиртайд хэдийд очсон бэ?

1930 хэдэн оны үед очсон. Хэрийн дуган, Өнөрчийн дуган, Хужиртайн дуган бол нэг л дуган. Би энэ тухайг нутгийн олон настай хүмүүсээс сонсч дуулж байсан.

-Энд төвд лам байсан уу?

Төвд лам байсан гэсэн шүү. Энүүхэн Ононгийн хойд дээр Ишийн Гомбо гэдэг хүн морьтой явж байсан чинь гурван настай хүүхэд явж байна гэнэ. Тэгэхээр нь хашраах гээд хулсан ташуураар далайтал нөгөө жижигхэн хүний гарт лаг гээд наалдчихаж. Тэр яах ч үгүй харин өөрийнх нь морь хөдөлдөггүй. Тэгээд нөгөөтөх чинь ухаан алдчихаж. Тэгээд хэдэн төвд лам нар хэд хоног гүрэм хийж байж дарсан гэдэг. Өнөрчийн дуганы хэдэн төвд лам нар дарсан гэдэг.

-Яагаад эндээсээ Хужирт руу нүүсэн юм бол?

Тэр одоо яасан юм бол доо. Хүн амьтныхаа олны хөлийг дагасан болов уу даа гэж л санаж байна. Нутгийн хүмүүс бол зүүн урд тал руугаа нутаглаж байсан юм. Онон гэдэг чинь их том. Одоогийнх шиг биш. Даваа гэж байна.

-Ононы Элст хошуу гэж хаана байдаг юм бэ?

Тэнд хийд байсан гэж байна уу?

-Тийм ээ,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр чинь яг эндэх шиг ийм хэдэн улиастай Ононгийн урд талд ийм газар. Одоо сүүлийн үед Элсэн толгой гэдэг болсон. Өнөрчөөс Элст хошуунд тэгээд тэндээсээ Хужиртад очсон юм. Гэхдээ тэнд удаагүй.

-Хэрийн дуганыг Хужиртайд нүүж очиход тэнд хийд байсан уу?

Байгаагүй. Байгаагүй шүү. Яагаад тэрийг сайн мэдэж байна гэхээр манай аав Хужиртайн дуганы Юм судрыг хувьсгалын үед нүүж авчраад хадгалж байгаад 1956 онд бие нь муудаад ирэхээр Өвөр Монголоос ирсэн Үзэмчин хошууны хийдэд морин тэрэгтэй аваачиж тушаасан байгаа. Тэгсэн 1957 онд нөгөө хийд нь татан буугдаад Гандантай нэгдчихсэн. Хэрлэнбаяны хийдийн ном тийшээ очсон гэж манай аав хэлж байсан. Одоо данс нь байх ёстой гээд, Гончигийн Дамдин гэдэг хүн тушаасан гэдэг байсан.

-Энэ хийдийн шүтээн сахиуснаас нь үлдсэн зүйлс байдаг болов уу? Танд хадгалагдаж байгаа зүйл байгаа юу? Надад юм байхгүй. Хүмүүс цаг хэцүү боллоо гээд бүгдийг нь л үгүй хийчихсэн шүү дээ. Харин Лувсандорж өвгөний охинд юм байж магадгүй. (Хэрийн дуганы хийморийн сангийн барыг хадгалж байсны зургийг авсан.)

-Энд зохиол бүтээл туурвиж байсан лам нар байсан болов уу?

Байсан л байх даа. Би сайн мэдэхгүй. Навааншарав гэдэг лам байсан тэр бол туурвиж л байсан байх.

-Хийдэд ном барладаг байсан уу?

Доржзодовыг монголоор барладаг байсан.

-Хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан бол?

Одоо мэдэхгүй. Санчинбалбарлин л байх даа.

-Эндээс тодорсон хутагт хувилгаад гэж байсан уу?

Ёстой мэдэхгүй. Тэр Лувсандорж амбаа гэдэг чинь нэлээн чадалтай хүн байсан. Энэ Шарав гуай чинь аль хийдийнх юм бэ?

Цэрэнтогтох: Ямар Шарав?

Дугар эмчийн аав.

Цэрэнтогтох: Шаравжамц гуай юу. Эндхийнх (Хэрийн дуганых) байхаа.

Уг нь юм хэлбэл хэлэх. Даанч одоо чадалгүй болжээ.

-Хийдэд дацангууд байсан уу? Чойр, Манба зэрэг.

Зодын ном голлодог байсан гэсэн.

-Тэгвэл улааны талын хийд байсан юм болов уу даа.